

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Дизель хөдөлгүүр
(HYUNDAI 500LC-7A экскаватор)** нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202112033**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “Дизель хөдөлгүүр (HYUNDAI 500LC-7A экскаватор)” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Үнэлгээнд ашиглах санхүүгийн тайлан ирүүлэх жил: **2019 оны жилийн эцэс, 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан**

Тендерийн хамт: 1 240 000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг тус тус ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас: 450060 + 188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ